



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН ТӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/40/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 51-261628 Цахим хаяг: natsagdorj@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас: 51-261628 Цахим хаяг: derdenechimeg@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: Ажу мэргэн Аудит ХХК
Захирал: Л.Насанбуян Утас: 7011-3008
Цахим хаяг: Ajumergenaudit.mon@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.1 Залруулсан алдаа.....	16
8.2 Албан шаардлага	16
8.3 Зөвлөмж.....	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АГАДҮТ	Ажил гүйлгээний анги дансны үлдэгдэл,тодруулга
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
НА	Нотлох ажил
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨААТҮГ	Төрийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БУЯНТ-УХАА СПОРТЫН ОРДОН
ТӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Л.ЭНХБАЯР ТАНАА

2022.03.15 № 07/545

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 326.0 сая төгрөгийн зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.2, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тайлант оны нийт орлогыг 1,187.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,242.7 сая төгрөгөөр алдагдлыг 55.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлээр 260.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1,999.6 сая төгрөгийн зардал гаргаж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хассан дүнгээр үйл ажиллагаанаас 420.9 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

Орлогын гүйцэтгэл 260.0 сая төгрөг болж төлөвлөснөөс 927.5 сая төгрөг буюу 78 хувиар буурсан нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас тус спортын ордонд хийгдэх арга хэмжээ хязгаарлагдаж орлого олох боломжууд алдагдсан нь нөлөөлсөн байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын удирдлага 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үр дүнгийн гэрээг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргатай байгуулдаг ба биелэлтийг дүгнэх хугацаа болоогүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	38,944,742.72	35,853,984.97
1.1.2	Дансны авлага	119,027,375.86	64,720,409.26
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	(0.00)	-
1.1.4	Бусад авлага	-	11,930,621.39
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	96,272,723.72	64,441,583.03
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	2,750,000.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	254,244,842.30	179,696,598.65
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	47,928,280,349.88	46,627,775,135.01
1.2.2	Биет бус хөрөнгө	460,537,083.58	460,537,083.58
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	48,388,817,433.45	47,088,312,218.59
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	48,643,062,275.76	47,268,008,817.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	32,678,123.58	47,681,947.52
2.1.1.2	Цалингийн өглөг	-	38,232.90
2.1.1.3	Татварын өр	442,116,995.34	145,982,690.11
2.1.1.4	НДШ - ийн өглөг	13,196,335.62	689,001.56
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	51,950,000.00	62,200,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	539,941,454.54	256,591,872.09
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	539,941,454.54	256,591,872.09
	ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.3	Өмч		
2.3.1	-төрийн	29,408,582,053.34	29,408,582,053.34
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	25,938,458,763.97	25,938,458,763.97
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	458,640,000.00	458,640,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(7,702,559,996.10)	(8,794,263,872.16)
2.3.11	Эздийн өмчийн дүн	48,103,120,821.21	47,011,416,945.15
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	48,643,062,275.76	47,268,008,817.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	250,705,591.07	259,975,590.92
2	Борлуулалтын өртөг	87,824,213.20	70,943,500.00
3	Нийт ашиг (алдагдал)	(64,345,563.31)	189,032,090.92
4	Үйлчилгээний орлого	3,727,272.73	-
5	Хүүний орлого	889,898.12	-
6	Гэрээний орлого	207,666,359.36	-
7	Түрээсийн орлого	19,560,581.82	-
8	Бусад орлого	19,751,377.16	647,874,661.21
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,852,469,459.25	1,926,341,145.02
11	Санхүүгийн зардал	166,160.00	-
12	Бусад зардал	6,412,292.00	4,031,937.50
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	1,153,073.33
17	Бусад ашиг (алдагдал)	-	609,381.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,671,797,985.37)	(1,091,703,876.06)
19	Орлогын татварын зардал	88,989.81	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,671,886,975.18)	(1,091,703,876.06)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,671,886,975.18)	(1,091,703,876.06)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(1,671,886,975.18)	(1,091,703,876.06)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	458,640,000.00	(6,007,194,371.03)	49,798,486,446.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	458,640,000.00	(6,007,194,371.03)	49,798,486,446.28
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,695,365,625.07)	(1,695,365,625.07)
2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	458,640,000.00	(7,702,559,996.10)	48,103,120,821.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	458,640,000.00	(7,702,559,996.10)	48,103,120,821.21
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,091,703,876.06)	(1,091,703,876.06)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	29,408,582,053.34	25,938,458,763.97	458,640,000.00	(8,794,263,872.16)	47,011,416,945.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	481,399,781.21	320,231,395.03
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	430,342,858.60	300,631,590.03
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,781,341.00	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	49,275,581.61	19,599,805.00
1.2	Мөнгөн зарлагын дүн	748,771,136.81	710,595,212.40
1.2.1	Ажиллагчдад төлсөн	253,844,385.33	202,227,085.49
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	50,231,500.93	75,978,569.70
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,678,640.00	81,279,229.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	150,244,175.21	180,839,198.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	14,044,250.00	8,814,540.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	88,989.81	134,103,161.08
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	106,920.00	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	265,532,275.53	27,353,428.24
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(267,371,355.60)	(390,363,817.37)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	889,898.12	396,538,959.62
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	380,658,959.62
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	15,880,000.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	889,898.12	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	9,265,900.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	3,699,900.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	4,356,000.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	1,210,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	889,898.12	387,273,059.62
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(266,481,457.48)	3,090,757.75
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	305,426,200.20	38,944,742.72
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	38,944,742.72	35,853,984.97

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 он		Зөрүү	хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт					
2	Нийт орлого	250,705.6	1,187,473.6	259,975.6	(927,498.0)	22
	Үндсэн үйл ажиллагааны орлого	227,226.9	1,187,473.6	259,975.6	(927,498.0)	22
3	Нийт зардал	1,946,071.2	1,242,660.0	1,999,554.2	756,894.2	161
	Үүнээс : Удирдлагын зардал		46,580.4	43,669.0	(2,911.4)	94
	Үйл ажиллагааны зардал	728,524.0	750,322.6	637,237.7	(113,084.9)	85
	Элэгдлийн зардал	1,217,547.2	445,757.0	1,318,647.5	872,890.5	296
4	Татварын өмнөх ашиг алдагдал	(1,695,365.6)	(55,186.4)	(1,739,578.6)	(1,684,392.2)	3152
5	Цэвэр ашиг алдагдал Элэгдлийн зардал ороогүй	(477,818.4)	390,570.6	(420,931.1)	(811,501.7)	-108
6	Төсвийн төлбөрт төлсөн Үүнээс		433,612.6	516,569.1	82,956.5	119
	НӨАТ		273,903.0	277,813.3	3,910.3	101
	НДШ		76,667.6	75,978.6	(689.0)	99
	ХХОАТ	19,264.0	29,422.0	37,671.4	8,249.4	128
	Үл хөдлөх хөрөнгийн татвар		25,500.0	93,323.3	67,823.3	366
	Газар		27,920.0	31,582.5	3,662.5	113
	Тээврийн хэрэгслийн албан татвар		200.0	200.0	-	100
8	Нийт ажилчдын тоо	33	33	33	-	100
9	Нийт цалингийн сан	264,542.7	283,652.0	278,695.5	(4,956.5)	98
10	Нэг ажилтны дундаж цалин	668.0	716.3	703.8	(12.5)	98
11	Борлуулалтын нэгж төгрөгт ногдох зардал	7.8	1.0	7.7	6.6	
12	Хөрөнгө оруулалт				-	
13	Нийт авлага	119,000.0		76,519.5	76,519.5	
	Үүнээс : Найдваргүй			-	-	
	Нийт өглөг	539,900.0		256,591.9	256,591.9	
14	Богино хугацаат өр төлбөр: Үүнээс	539,900.0		256,591.9	256,591.9	
	Татвар НДШ-ийн өр			146,671.7	146,671.7	
	Урьдчилж орсон орлого			62,200.0	62,200.0	
	Урт хугацаат өр төлбөр			-	-	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, үр ашгийг дээшлүүлэх, татварын тайланг үнэн зөв тайлагнах, нягтлан бодох бүртгэлийн программын сайжруулалт хийлгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 2 дүгээр сарын 12-наас 2022 оны 3 дугаар сарын 11-ний хооронд Ажу мэргэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал Л.Насанбуян, аудитор Д.Наранчимэг, туслах аудитор Д.Шандбаяр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг менежер Л.Долгорсүрэн хэрэгжүүлсэн.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 2 дугаар сарын 23 -ны өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогт тохируулан сайжруулах шаардлагатай.

Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Биеийн тамир, спортын улсын хорооны хяналт үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2019-2021 оны санхүү эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Шалгалтаар худалдан авах ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, хөрөнгийн орлого, зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж өгч, биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтааж ирүүлэх үүрэг өгсөн байна.

Дотоод аудитаас өгсөн зөвлөмжийн талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

АХГ-2022/40/НА-ТӨА

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардал 1,852.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 18.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын үйл ажиллагааны зорилго нь Монгол улсад биеийн тамир, спортын талаар төрөөс явуулж буй бодлогын хэрэгжилтийг хангах, төрөөс баримтлах бодлогод тусгасан зорилгыг хэрэгжүүлэх, иргэдийн дунд нийтийг хамарсан биеийн тамир, спорт, чийрэгжилтийн арга хэмжээ, олон улс, тив, дэлхийн тэмцээн, соёл урлагийн болон бусад арга хэмжээг зохион байгуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлэхэд оршино.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит ААТҮГазар гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Буянт ухаа спортын ордон ТӨААТҮГ нь Монгол, БНХАУ-ын Засгийн газрын эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны гэрээ хэлцлийн хүрээнд байгуулагдаж 2010 оны 12 дугаар сарын 02-ны өдөр ашиглалтад орсон байна.

Буянт ухаа спортын ордон ТӨААТҮГ нь Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны харьяа, 2013 онд Соёл Спорт Аялал жуулчлалын яаманд харьяалагдан ажиллаж байгаад Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 55 дугаар тогтоолоор Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болж өөрчлөгдсөн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй:... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдан зохион байгуулдаг. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь үйлдвэрийн газрын захирлыг төрийн захиргааны холбогдох байгууллагатай зөвшилцөн томилж контрактын гэрээ байгуулан ажиллаж байна. Тус үйлдвэрийн газрын дүрмийн 6.5-д “Үйлдвэрийн газар нь захиралд зөвлөх үүрэг бүхий Захирлын зөвлөлтэй байж болно” гэж заасан боловч байгууллагын үйл ажиллагаа нь өргөн цар хүрээг хамардаггүй тул захирлын зөвлөл байгуулах шаардлагагүй гэж үзсэн байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь жил бүр үйлдвэрлэлийн цар хүрээ, эдийн засгийн үзүүлэлттэй нь уялдуулан бүтэц орон тоог нь баталдаг.

Тус ордны засвар үйлчилгээг хийж хэрэгжүүлэхээр БНХАУ-ын талаас Худалдааны яам, Монгол улсын талаас Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар харилцан АХГ-2022/40/НА-СТА-ТӨА

тохиролцож 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдөр хийх засвар үйлчилгээний хэмжээний дээд хязгаар нь 78.5 сая юань байхаар харилцан тохиролцож гэрээ байгуулсан байна.

Дээрх гэрээний дагуу 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын “Хөрөнгө гаргах тухай” 143 дугаар тогтоол гарч гэрээний дагуу Монголын талын гаргах зардал 796.9 сая төгрөг, Буянт ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын татварын хуримтлагдсан өр болох 390.5 сая төгрөг нийт 1,187.4 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэсэн байна.

Дээрх тогтоолын дагуу тайлант онд хуримтлагдсан татварын өрийг төлөхөд 390.5 сая төгрөг, засвар үйлчилгээний зардалд 255.3 сая төгрөгийг засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна.

Энэ хөтөлбөрийн дагуу биеийн тамир, спортын салбарын бодлогын үр нөлөөг дээшлүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, эрүүл чийрэг иргэнийг төлөвшүүлэх хэд хэдэн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд байгууллагын хашаан дотор 3500 мкв, хашааны гадна 30,000 мкв талбайгаа ашиглан өглөөний гүйлт, уран сайхны гимнастик болон үнэгүй фитнесийг явуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог нэгээр бууруулсан бөгөөд удирдлагын цалин хөлсийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргатай байгуулсан гэрээнд заасны дагуу олгож байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна.

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	38,944.7	35,853.9	(3,090.8)
Авлага	119,027.4	76,651.0	42,376.3
Бараа материал	96,272.7	64,441.6	(31,831.1)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	-	2,750.0	2,750.0
Үндсэн хөрөнгө	47,928,280.3	46,627,775.1	(1,300,505.2)
Биет бус хөрөнгө	460,537.1	460,537.1	-
Нийт хөрөнгийн дүн	48,643,062.3	47,268,008.8	(1,375,053.5)
Богино хугацаат өглөг	539,941.5	256,591.9	(283,349.6)
Эздийн өмч	48,103,120.8	47,011,416.9	(1,091,703.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	48,643,062.3	47,268,008.8	(1,375,053.5)

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 35.8 сая төгрөг болж 3.1 сая төгрөгөөр буурсан байна. Худалдаа хөгжлийн банк, Хаан банканд харилцах данстай, оны эцэст худалдаа хөгжлийн банканд 20.9 сая, Хаан банканд 14.9 сая төгрөг байршиж байна.

Тайлант хугацаанд спортын ордны барилгын их засварын ажилд зориулж Засгийн газрын нөөц сангаас олгосон 257.2 сая төгрөгийн санхүүжилтээс ажилчдын цалинд 111.2 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөрт 17.2 сая, ашиглалтын зардалд 97.2 сая, татвар, даатгалын төлбөрт 15.8 сая, хангамжийн материал, хоолны зардалд 15.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Авлагын үлдэгдэл оны эхнээс 42.3 сая төгрөгөөр буурсан. Авлагын дансны насжилтыг үзэхэд нийт авлагын 51.5 хувь буюу 39.4 сая төгрөг нь борлуулалтын хөнгөлөлт, буцаалтаас үүссэн, эзэн холбогдогч нь тодорхойгүй авлага байна.

Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэл 2.7 сая төгрөг нь бараа материалын үнийг урьдчилж шилжүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 64.6 сая төгрөг болж 31.1 сая төгрөгөөр буурсан нь аудитын зөвлөмжийн дагуу 16.7 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн ангилалд шилжүүлсэн, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй 26.5 сая төгрөгийн биеийн тамирын хувцас хэрэглэлийг бүртгэлээс хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 46,627.8 сая төгрөг болж, 1,300.5 сая төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 518 дугаар тогтоолын дагуу 116.6 сая төгрөгийн хөрөнгийг акталж, 1,318.6 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.1-д заасны дагуу ашиглалтын хугацааг тогтоож элэгдлийн зардлыг тооцож байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 256.6 сая төгрөг байгаа нь дансны өглөг 47.7 сая төгрөг, татварт төлөх өр 146.5 сая төгрөг, урьдчилж орсон орлого 62.2 сая төгрөг байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 1,091.7 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2020 оны 143 дугаар тогтоолын дагуу тус үйлдвэрийн газарт үүссэн татварын өрийг барагдуулахад 390.6 сая, спортын ордны их засварт зориулж 257.3 сая төгрөгийг Засгийн

газрын нөөц сангаас санхүүжүүлсэн дүнгээр нэмэгдэж, тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн 1,739.6 сая төгрөгөөр буурсан.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 “Төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох 20 дугаар зүйлийн 1.3 “Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах” гэж заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал нь байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын даргаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 642 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 1,187.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,242.7 сая төгрөгөөр алдагдлыг 55.2 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Зорилтот түвшний төлөвлөгөөг батлахдаа үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг зөрүүтэй тооцсон нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, түүний биелэлтийг нийт дүнгээр дүгнэхэд хүндрэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хассан дүнгээр үйл ажиллагаанаас 420.9 сая төгрөгийн алдагдал хүлээсэн байна.

2020-2021 онд дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас тус спортын ордонд хийгдэх арга хэмжээ хязгаарлагдаж орлого олох боломжууд нь алдагдсан байна. Байгууллагын тогтмол зардлыг орлогоороо нөхөх боломжгүй болсон нь алдагдал өсөж, хуримтлагдсан өр төлбөр өсөхөд нөлөөлсөн байна.

2021 оны 5 дугаар сард Улсын онцгой комиссын шийдвэрээр болзошгүй бэлэн байдлыг хангахтай холбоотой 300 ор дэлгэснээс 56.7 сая төгрөг, 9 дүгээр сараас УОК-ын зөвшөөрөлтэй үзэсгэлэн худалдаа, Voice Mongolia-2021 телевизийн нэвтрүүлэг, шинэ жилийн хүлээн авалтуудыг халдвар хамгааллын дэглэм баримтлан амжилттай зохион байгуулснаас 203.2 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого олсон байна.

Тайлант хугацааны нийт зардал 1,999.6 сая төгрөг байгаагаас үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 1,318.6 сая, цалин, нийгмийн даатгалын зардал 296.5 сая, татвар, төлбөр хураамжийн зардал 75.8 сая, ашиглалтын зардал 97.2 сая, үйл ажиллагааны арга хэмжээний зардал 142.5 сая, шатахууны зардал 5.4 сая, засвар, мэргэжлийн үйлчилгээний зардал 26.3 сая, тоног төхөөрөмжийн түрээсийн зардал 9.5 сая, бусад хоол, хангамжийн зардал 27.8 сая төгрөг байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 119 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 10 тайлан мэдээг

ил тод байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 24.0 сая төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй, 105 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 46.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 40.6 сая төгрөгийг залруулж, өмнөх оны санхүүгийн тайлангаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, татварын тайланг үнэн зөв тайлагнах, мөнгөн хөрөнгийн анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах зэрэгт өгсөн зөвлөмжийн биелэлт 82.1 хувьтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 652.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 552.1 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 100.3 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс албан шаардлагын хэрэгжилт 81 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	552.1	2	552.1	1	-	81.0
Зөвлөмж	5	100.3	4	100.3	-	-	100.0
Нийт дүн	8	652.4	6	652.4	1		90.5

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын үл хөдлөх хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан эрх зүйн бичиг баримтыг бүрдүүлж, Улсын комисст хүлээлгэн өгөх арга хэмжээ авч, алдаа зөрчлийг арилгах албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Улсын комиссын 2011 оны 12 дугаар сарын 21-ний хурлын тэмдэглэлд орсон 15 төрлийн ажлыг хийж гүйцэтгэж, барилгыг улсын комисст хүлээлгэн өгөхөд шаардлагатай ажлуудыг хийж гүйцэтгэж байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын засгийн газар хоорондын 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн солилцох захидлын дагуу "Буянт-Ухаа спортын ордны үйлчилгээний төслийн хэрэгжүүлэлтийн гэрээ"-ний дагуу тус ордонд их засварын ажил хийгдэж байгаатай холбоотой санхүүжилт, түүний зарцуулалт, хөрөнгийн бүртгэл, үр дүнгийн талаар анхаарал хандуулж ажиллах шаардлагатай.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 482.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 156.1 сая төгрөгийн алдааг залруулж, 296.8 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 29.2 сая төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 326.0 сая төгрөгийн алдаа зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 18.5 сая төгрөгөөс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 156.1 сая төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Урьдчилж төлсөн зардал дансанд тайлант хугацааны зардлыг бүртгэж үр дүнг 40.6 сая төгрөгөөр буруу тайлагнасан;
- Тайлант хугацааны орлого 115.5 сая төгрөгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж үр дүнг буруу тайлагнасан.

8.2 Албан шаардлага

1. Эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 39.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "...төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлагын дансны үлдэгдлийг насжилтаар нь ангилж, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, эзэн холбогдогч тодорхойгүй авлагыг шүүхэд шилжүүлж тогтоолгох албан шаардлага хүргүүлэв.

2. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Хөрөнгө гаргах тухай" 143 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлсэн, спортын ордны барилгын их засварт зориулагдсан 257.3 сая төгрөгийн хөрөнгийг тайлант үеийн үйл ажиллагааны зардалд зарцуулж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3."Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно", 25.4."Төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэх нь: Төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж байх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3..Тус байгууллага нь Төсвийн тухай хуульд заасан хуулийн хугацаанаас санхүүгийн тайланг 8 хоног хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8. "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэх нь: Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд ирүүлж байх албан шаардлага хүргүүлэх.

4. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 642 дугаар тогтоолоор 2021 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үндсэн хөрөнгийн элэгдэл хассан дүнгээр 390.5 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 420.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэх нь: Албан шаардлага хүргүүлэх

8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Ковид-19 цар тахлын үед коронавирусын халдвар авсан 9 ажилтанд 1.8 сая төгрөгийн эмчилгээ, эм тарианы мөнгө олгож тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллаагүй байна. Энэ нь Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1."Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах, байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулж дотоод журмын дагуу олгож байгаа тэтгэмжийн асуудлыг шийдвэрлэх

2. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Буянт-Ухаа спортын ордны эрчим хүчний эх үүсвэрээс Сод монгол группийн ШТС, иргэн Сүхбаатар, Алцгар хуушуур ХХК, Юникл Таувэр ХХК зэрэг байгууллагууд цахилгаан эрчим хүчээр хангагдаж нэг тоолуураар бичилт хийгдэж байна. Эдгээр газруудын хэрэглэсэн цахилгааныг сар бүр авлага үүсгэж бүртгээгүй, 3.1 сая төгрөгийн төлбөрийг дутуу нэхэмжилж цахилгааны зардлыг нэмэгдүүлж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг,авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Харьяа дүүргийн хэрэглэгчдэд үйлчлэх төв болон Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК-д хүсэлт гаргаж тэдгээр байгууллагуудыг цахилгааны тоолууртай болгох, тоолуурын заалтын дагуу авлагаар бүртгэж тухай бүр төлбөрийг барагдуулж байх, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

3. Татварын тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийг и баримтаар баталгаажуулж байх, санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын өглөг, татварын тайлангийн үлдэгдлээс 24.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5."...Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин

давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материал худалдан авах, ажил үйлчилгээний төлбөрийг И баримтаар баталгаажуулж ажиллах, татвар, санхүүгийн тайлангийн уялдааг сайжруулж, үнэн зөв тайлагнаж байх.

4. Программ хангамжтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Одоогийн ашиглаж байгаа Санхүүгийн тооцоолох группын "Healter" нягтлан бодох бүртгэлийн программ нь санхүүгийн тайлан, хураангуй ба дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж тайлагнахад шаардлага хангахгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 47 тоот тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ын холбогдох заалтыг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Аж ахуй нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлагуудыг бүрэн хангасан өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцсэн, хөрвөх боломжтой санхүүгийн программ хангамжийг судалж, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдаж авах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгуулагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа зөрчил		Үүнээс:							
							Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Урьдчилж төлсөн зардал дансанд тайлант хугацааны зардлыг бүртгэж үр дүнг буруу илэрхийлсэн	Тайлант хугацааны зардлаар бүртгэх	1	40,621.3	1	40,621.3						
2	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Тайлант хугацааны орлогыг урьдчилж орсон орлого дансанд бүртгэж үр дүнг буруу илэрхийлсэн	Урьдчилж орсон орлого данснаас, /НӨАТ салгаж/ тайлант үеийн орлого руу залруулж бүртгэх	1	115,472.7	1	115,472.7						
3	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайланг хуулийн хугацаанаас 8 хоногоор хоцроож ирүүлсэн.	Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлж байх зөвлөмж өгөх	1						1			
4	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Засгийн газрын нөөц сангаас гаргасан спортын ордны барилгын их засварт зарцуулагдах хөрөнгийг тайлант үеийн үйл ажиллагааны зардалд зарцуулж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.	Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага өгөх	1	257,273.5					1	257,273.5		
5	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Авлагын дансны үлдэгдлээс 16 хувь хүн хуулийн этгээдийн 39,4 сая төгрөгийн авлага нь эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	Авлагыг тодруулж холбогдох дээд байгууллага болон шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх	1	39,473.1					1	39,473.1		
6	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020 оны 642 дугаар тогтоолоор 2021 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үндсэн хөрөнгийн элэгдэл хассан дүнгээр 390.5 сая төгрөгийн ашигтай байхаар баталсан боловч гүйцэтгэлээр 420.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	Төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж үр дүнг нэмэгдүүлэх албан шаардлага өгөх							1			

**Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан**

7	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Ковид-19 цар тахлын үед корона вирусын халдвар авсан 9 ажилтанд 1.8 сая төгрөгийн эмчилгээ, эм тарианы мөнгө олгож тэвчиж болох зардлыг хэмнэж ажиллаагүй байна.	Засгийн газрын тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй тул зөвлөмж өгөх	1	1,800.0						1	1,800.0	
8	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Одоогийн ашиглаж байгаа Санхүүгийн тооцоолох группын "Healter" нягтлан бодох бүртгэлийн программ нь санхүүгийн тайлан, хураангуй ба дэлгэрэнгүй бүртгэл хөтөлж тайлагнахад шаардлага хангахгүй байна.	Санхүүгийн программ хангамжийг сайжруулах зөвлөмж өгөх	1							1		
9	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний төлбөрийг и баримтаар баталгаажуулаагүй, санхүүгийн тайлан дахь НӨАТ-ын өглөг, татварын НӨАТ-ын тайлангийн үлдэгдлээс 24.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна	Албан татвар суутган төлөгчөөс төлбөрийн баримтыг тухай бүр авч байх, борлуулалтын НӨАТ-ыг зөв тайлагнах зөвлөмж өгөх	1	24,338.9						1	24,338.9	
10	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Буянт-Ухаа спортын ордны эрчим хүчний эх үүсвэрээс Сод монгол группын ШТС, иргэн Сүхбаатар, Алцгар хуушуур ХХК, Юникл Таувэр ХХК зэрэг байгууллагууд цахилгаан эрчим хүчээр хангагдаж нэг тоолуураар бичилт хийгдэж байна. Эдгээр газруудын хэрэглэсэн цахилгааныг сар бүр авлага үүсгэж бүртгэдэггүй, төлбөрийг дутуу нэхэмжилж цахилгааны зардлыг нэмэгдүүлж байна.	Тухайн байгууллагын хэрэглэсэн цахилгааны дүнгээр зардал бүртгэх, эдгээр байгууллагуудын хэрэглэсэн цахилгааны тоолуурын заалтын дагуу авлага бүртгэж тухай бүр төлбөрийг барагдуулж байх, хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн	1	3,125.0						1	3,125.0	
НИЙТ ДҮН					9	482,104.5	2	156,094.0	0	0	4	296,746.6	4	29,263.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	БУСО	АХГ-2022/40/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн санд 119 мэдээлэл оруулахаас хугацаа хоцроосон 107, мэдээлэл оруулаагүй 10, таван сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй 24,0 сая төгрөгийн 2 гүйлгээний мэдээлэл оруулаагүй байна.	Өмнө жилийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй тул хариуцлага тооцох албан шаардлага өгөх.	1	24,092.0						1	24,092.0	
ДҮН					1		-	-	-	-	1	24,092.0	-	-
НИЙТ ДҮН					10	506,196.5	2	156,094.0	-	-	5	320,838.6	4	29,263.9



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 351/А0150458
АХГ-2022/40/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанаас 8 хоног хоцроож ирүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8.9.8. "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанд ирүүлж байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал Л.Энхбаяр, нягтлан бодогч А.Халиун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Д.НАСАНБУЯН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 352/АД150458

Улаанбаатар хот

АХГ-2022/40/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Хөрөнгө гаргах тухай" 143 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлсэн, спортын ордны барилгын их засварт зориулагдсан 257,273,507.00 төгрөгийн хөрөнгийг тайлант үеийн үйл ажиллагааны зардалд зарцуулж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3. "Засгийн газрын нөөц сангаас олгох санхүүжилтийг тухайн төсөл, арга хэмжээ, ажил, үйлчилгээг хэрэгжүүлж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүний харилцах дансанд шууд шилжүүлэхийг хориглоно", 25.4. "Төсвийн ерөнхийлөн захирагч нь Засгийн газрын нөөц сангийн санхүүжилтээр тухайн салбарт хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавина" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Засгийн газрын нөөц сангийн хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал Л.Энхбаяр, нягтлан бодогч А.Халиун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardiaga\2022\03\15 Auditin 2 Gazar-28.Docx

0010801029



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 354/А015045Р

Улаанбаатар хот

АХГ-2022/40/НА-СТА-ТВА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эзэн холбогдогч нь тодорхойгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй 16 хувь хүн, хуулийн этгээдийн 39,473,144.00 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "...төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "...дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээ гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дансны авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, эзэн холбогдогч тодорхойгүй авлагыг барагдуулах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал Л.Энхбаяр, нягтлан бодогч А.Халиун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 353/АД/150458

Улаанбаатар хот

АХГ- 2022/40/НА-СТЭ-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 642 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг үндсэн хөрөнгийн элэгдэл хассан дүнгээр 390,570,600.00 төгрөгийн ашигтай байхаар баталсан нь гүйцэтгэлээр 420,931,100.00 төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 "Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргатай байгуулсан гэрээний дагуу зорилтот түвшний хүрэх үр дүнгийн хэрэгжилтийг хангаж ажиллах, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал Л.Энхбаяр, нягтлан бодогч А.Халиун нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.НАСАНБУЯН

0010801117



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 350/АД150458
АХГ-2022/40/НА-СТА-ТВА

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулахаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 119 мэдээлэл оруулахаас 2 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 10 тайлан мэдээг ил тод байршуулаагүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 24.0 сая төгрөгийн 2 гүйлгээг байршуулаагүй, 105 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчил гаргасан буруутай албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Буянт-Ухаа спортын ордон ТӨААТҮГ-ын захирал Л.Энхбаярт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ
АЖУ МЭРГЭН АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Л.НАСАНБУЯН



ТЭМДЭГЛЭЛ

A series of horizontal dotted lines for writing the summary.

